



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.04.15, ДАВАА ~ №069 (1121)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Багшийн хөгжлийг дэмжих тогтоол гаргав

Багшийн ажлын байрны нөхцөлийг сайжруулах үүргийг ХНХ-ын сайдад өгөв.

>2

Дотоодын шоколадны хэрэгцээг хангах зорилготой Sayan брэнд

Албан байгууллага болон хувь хүмүүсийн захиалгаар шоколадаа хийдэг.

>5

Б.Дашдондог: Монгол рок урсгалыг дэлхийд таниулах зорилготой

Хүннүчүүдийн товшуур хөгжмийн кварц рок урсгалын үндсэн хөг юм.

>6

ZGM DAILY

FULL
ENGLISH PAGE
INSIDE

>7


ОНЦЛОХ

УЛС ТӨР

С.Зоригийн хэргийг шалгах түр хороо байгуулах асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцэхийг дэмжив.
МАН-ын Бага хурал энэ сарын сүүлээр болж, нөхөн сонгуульд нэр дэвшигчээ тодруулна.
УИХ-ын дарга 25 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус бодлогын зөвлөл байгуулав.
Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төслөөс МАН-ын бүлэг завсарлага авлаа.

ЭДИЙН ЗАСАГ

Southgobi Resources-ийн нүүрсний борлуулалт 2018 онд 1.6 дахин буурчээ.
“Монос хүнс” 122.7 сая хувьцааг нэг бүрийг нь 70 төгрөгөөр санал болгоно.
“Техник импорт” энэ онд борлуулалтын орлогоо 30 хувиар нэмэгдүүлнэ.
Топ 20 индекс 0.79 хувиар өсөж, 20010.13 нэгжид хүрсэн байна.



НИЙГЭМ

“Гоодойн ам” зуслангийн бүсэд гал гарч, 20 гаруй айлын байшин шатлаа.
Өнөөдрөөс эхлэн автомашины дугаарын хязгаарлалт зуны бүсэд шилжиж байна.
ХУД-ийн VIII хороонд өвлийн спортын ордны шав тавих ёслол боллоо.
Зургаан дээд сургуулийн зөвшөөрлийг цуцалж, гурван ЕБС-д хугацаатай үүрэг өгөв.

ДЭЛХИЙ

Хувьцаа эзэмшигчид Закербергийг Facebook-ийн тэргүүнээс огцруулах хүсэлтэй.
Британичууд Жереми Корбиныг шинэ Ерөнхий сайд гэж үзэж байна.
Венесуэлийн Мадурог дэмжихээ зогсоохыг АНУ, Бразил хоёр ОХУ-д уриалав.
Өмнөд Солонгосын LG компани тунгалаг дэлгэцтэй телевиз сонирхууллаа.

ЦАГ АГААР


УЛААНБААТАР

2017.04.15



16° | 2°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

КОКСЖИХ НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СЭРГЭЛТ ҮРГЭЛЖИЛНЭ



“Дэлхийн коксжих нүүрсний нөөц ба зах зээл” сэдэвт олон улсын чуулган Бээжин хотноо энэ сарын 10-11-нд боллоо. Монголыг харах өмнөд хөршийн бодлого өөрчлөгдөж, манай улсаас авах коксжих нүүрсний хэмжээгээ энэ онд өсгөх боломжтой гэж Хятадын тал мэдэгдлээ. ▶12

С.Батсайхан / ЗГМ©

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Элчинг зүхэхийн оронд эрх баригчдаасаа хариуцлага нэх

Б.Сэлэнгэ
ЗГМ

Солонгост 50 орчим мянган монгол иргэн ажиллаж, амьдарч байгаа. Энэ бол Монголын нэг аймгийн хүн амтай тэнцэх хэмжээний тоо. Харьцуулж харвал Дундговь аймгийн хүн амтай тэнцэх бол Говьсүмбэрийнхээс 30 гаруй мянгаар илүү гэсэн үг.

Өнөөгийн сонгуулийн системээр тооцвол нэг мандаттай сонгуулийн томоохон тойрог гэж нэрлэсэн ч болно. Харин эдийн засгийн утгаар нь харвал Солонгос нь Монголын хамгийн том “ажил олгогч” юм. Энэ ч утгаараа Солонгост байгаа монголчуудын амин зуулга, ашиг олз өнөөгийн Монголын эдийн засгийн салшгүй нэгэн хэсэг болоод байгаа юм. Мөн Солонгос улстай холбоотой

мэдээ мэдээлэл, гадаад ажиллах хүч, аялал жуулчлалын бодлого тэр ч байтугай эдийн засгийн ололт, доргио чичиргээг монголчууд андахгүй мэдэрдэг болжээ.

Үүний нэг нотолгоо нь өнгөрсөн долоо хоногийн сүүлээр БНСУ-аас Монголд суух Элчин сайдын яамнаас гаргасан мэдэгдэл байв.

►3

ЭДИЙН ЗАСАГ

Мөнгөтэй, өргүй хөх захтны шинэ ирээдүй

Майкл Сассо

Флорида муж улсын Тампа дахь Бишоп МакЛафлины католик ахлах сургууль төгсөгчдөө 100 хувь их сургуульд элсдэгийг сурталчлах дуртай. Ийм сурталчилгаа АНУ-ын бусад ахлах сургуульд ч байдаг л зүйл.

Харин энэ жил тус сургууль элсэгчдээ 100 хувь их сургуульд элссэн тухай анх удаа

сайрхах аргагүй болж байна. Флоридагийн их сургуульд элсэж дахиад дөрвөн жил эрдэм сурахын оронд ус халаагч суурилуулж, ус алддаг жорлон засдаг сантехникийн слесарь хийнэ хэмээн тус сургуулийг төгсөгч Кассиан О’Нил мэдэгджээ.

“Ширээний ард өдөржин сууж, компьютер шагаймааргүй

байна” хэмээн 19 настай Кассиан тайлбарлав. “Биений хүчний хөдөлмөр эрхлэх дуртай болохоор слесарь, цахилгаанчин, гагнуурчин л сайхан санагдаад байна. Тэгээд ч слесарийн цалин сайн, хийдэг хүн нь цөөрөөд байгаа тул цаашдаа бүр л өснө” хэмээн залуу өгүүлсэн юм.

►9

KING TOWER
LUXURY APARTMENT & PENTHOUSE

Германы №1 MIELE-тэй ХАВРЫН УРАМШУУЛАЛ

Монголын хамгийн анхны дотроо сургууль цэцэрлэгийн цогцолбортой хотхоны KING TOWER апартментаас хүссэн орон сууцаа сонгон гэрээ хийж буй эрхэм захиалагчдадаа цахилгаан бараагаар дэлхийд тэргүүлэгч, 150 жилийн баталгаат Германы №1 MIELE брэндийн гэр ахуйн цахилгаан барааг бэлэглэж байна. Эрхэм та “KING TOWER APARTMENT”-ын 58 - 205 мкв талбай бүхий CRYSTAL, DIAMOND, DUPLEX болон PENTHOUSE ангилалаас мкв харгалзахгүйгээр, өөрийн хүссэн орон сууцыг сонгон жилийн 3 - 6% хүүтэй ОНЦГОЙ ЗЭЭЛ-д хамрагдах боломжийг зөвхөн бид санал болгож байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг
99250462, 88114186

АЛТ

1290.43
0.16%

ЗЭС

6484
1.19%

10-ЧИНГИС БОНД

98.700
0.13%

ХУРАЛДАЙ БОНД

110.70
0.12%

ГЭРЭГЭ БОНД

99.330
0.12%

АМ.ДОЛЛАР

2631.77

ЮАНЬ

391.71

РУБЛЬ

40.79

Улс төр

С.Зоригийн хэргийг хянах түр хороо байгуулахыг дэмжлээ

Хэргийн нотлох баримтыг харуулсан 70 минутын бичлэгийг гишүүд үзэхийг хүсэв

П.Батбөх
ЗГМ

Парламентын түүхэнд анх удаа эрүүгийн хэргийг хянан шалгах түр хороо байгуулахыг УИХ-ын гишүүд дэмжлээ. Өнгөрсөн онд ЖДҮХС-гийн эрүүгийн хэргийг шалгах түр хороо байгуулах санал гаргаж байсан боловч гишүүдийн олонх дэмжээгүй юм. Харин энэ удаад С.Зоригийн хэргийг хянах түр хороо байгуулах тогтоолын төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн 74 хувь нь дэмжсэнээр парламент мөрдөн шалгах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох нэгэн субъекттэй болох эрх нээгдлээ.

Олон улсын парламентын холбооноос “Монгол Улсын дээд шүүхийн шийдвэрээр, 2017 онд эцэслэн шийдвэрлэсэн С.Зоригийг хөнөөсөн хэргийн шүүн таслах ажиллагаа нь хүний эрхийн хэмжүүр болон шударга шүүхийн зарчимд нийцээгүй” хэмээн үзжээ. Мөн тус зөвлөл уг хэргийг шударга шүүхээр шийдвэрлэнэ гэдгийг баталгаажуулах үүднээс УИХ дэргэдээ парламентын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх шинэчилсэн хороо байгуулахыг уриалжээ. Мөн 2018 онд УИХ-ын даргын захирамжаар С.Зоригийг



С.Батсайхан / ЗГМ©

хөнөөсөн хэргийг шалгах ажлын хэсгийг таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж байсан бөгөөд тус ажлын хэсэг УИХ-аас хэргийг хянах түр хороо байгуулах зөвлөмж, дүгнэлтийг гарсан байжээ. Үүний дагуу түр хороо байгуулах тогтоолын төслийг УИХ-ын гишүүн Ж.Багзандан, Л.Болд, Ц.Нямдорж, Л.Оюун-Эрдэнэ, Я.Санжмятав, А.Сүхбат нар санаачлан, боловсруулжээ. Тус түр хороог байгуулснаар Зоригийн хэргийг шалгах явцад эрүүдэн шүүсэн болон мөрдөн байцаалтын үйл ажиллагаа үнэн, зөв явсан эсэхийг шалгах юм.

УИХ-ын гишүүдийн зүгээс түр хороо байгуулахын зэрэгцээ хэн тус хороонд орж ажиллахыг батлах нь чухал байгаа юм. Өнгөрсөн долоо хоногт Хууль зүйн

байнгын хороогоор хэлэлцэх үед УИХ-ын гишүүн О.Баасанхүү түр хороонд орж ажиллахаа мэдэгдсэн нь хэрүүл тарьсан.

Н.Учрал: Гишүүд Дээд шүүхийн шийдвэртэй бүрэн эхээр нь танилцмаар байна

Мөн УИХ-ын чуулганд танилцуулах үеэр ч О.Баасанхүү, Ж.Багзандан нарын хооронд хэрүүл болж, Ж.Багзандан О.Баасанхүүг нэр төрд нь халдсан,

доромжилсон үгсийг хэлсэн нь парламентын гишүүдийн ёс зүйд зохицгүй байсныг олон гишүүн шүүмжлэв.

Гишүүд түр хороонд орж ажиллахын тулд булаалдаж буйн цаад шалтгааныг 70 минутын бичлэгтэй холбон тайлбарлаж болно. Энэ хэрэгтэй холбоотой 26 минутын эрүүдэн шүүсэн бичлэгийг гишүүд, сэтгүүлчид, хүний эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл зэрэг 119 хүн үзсэн. Харин хэргийн нотлох баримтыг багтаасан 70 минутын бичлэг байгаа нь гишүүдийн сонирхлыг татаж байгаа юм. Б.Содномдаржаа, Т.Чимгээ, Ц.Амгаланбаатар нарыг яллах үндэслэл болсон нотлох баримтын тухай 70 минутын бичлэгийг УИХ-аас байгуулах

түр хороо болон Хүний эрхийн дэд хорооны хуралд хаалттай байдлаар гишүүдэд үзүүлэхийг чуулганд оролцсон гишүүд хүсэж байгаа юм. Харин УИХ-аас байгуулсан ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байсан гишүүн Х.Нямбаатар “Энэ хэрэгт холбогдсон Б.Содномдаржаа, Т.Чимгээ нарыг эрүүдэн шүүсэн хэргийг С.Зориг агсныг хөнөөсөн хэргээс тусад нь хэлэлцэхгүй бол сэтгэлийн хөөрлөөр асуудалд хандаж жинхэнэ алуурчдыг, захиалагчдыг илрүүлэх хэрэг буруу тийшээ явчих гээд байгааг анхаарах хэрэгтэй” гэсэн юм. Мөн УИХ-ын гишүүн Н.Учрал Дээд шүүхийн шийдвэртэй бүрэн эхээр нь танилцаж, 70 минутын бичлэгийг үзэх хүсэлтэй байна гэсэн юм. [ЗГМ]

Олон улсын парламентын холбооноос “С.Зоригийг хөнөөсөн хэргийн шүүн таслах ажиллагаа нь хүний эрхийн хэмжүүр болон шударга шүүхийн зарчимд нийцээгүй” хэмээн үзэж, парламентын хянан шалгах хороо байгуулахыг уриалжээ.

ЗГМ ТОВЧХОН

» **ПАРЛАМЕНТ**
УИХ-аас Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулж, сум, дүүргийн Засаг даргад ЕБС, цэцэрлэгийн удирдлагыг томилж, чөлөөлөх эрхийг олгосон бөгөөд энэ оны зурга дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэхээр тогтоогоод байсан юм. Харин өнгөрсөн баасан гарагийн чуулган хуралдаанаар уг хуулийн заалтын хэрэгжилтийг ирэх оны 2020 оны долдугаар сар болгон хойшлуулжээ.

» **БҮЛЭГ**
МАН-ын бүлгийн өнөөдрийн хурлаар Ерөнхийлөгчөөс өргөн барьсан ерөнхий прокурорын орлогчид нэр дэвшсэн М.Чинбат, С.Алиманцэцэг нарыг дэмжих эсэхийг хэлэлцэнэ. Өнгөрсөн долоо хоногт үүнийг хэлэлцэх ёстой байсан ч хэлэлцэх асуудлыг дараалал батлагдсаны дараа өргөн барьсан гэж бүлгийн дарга тайлбарлав.

» ТОО

\$3.1
Сая, БСШУСЯ-наас АХБ-тай хамтарч ажиллах хэлэлцээрт нэмэлт оруулж, ирэх хичээлийн жилд шаардлагатай сурах бичгийг хэвлүүлэх зардал болох 3.1 сая ам.долларыг нэмж тусгахаар болжээ. Ингэснээр тус банк ЕБС-уудыг сурах бичгээр бүрэн хангахад зориулж найман тэрбум төгрөгийн санхүүжилт хийх юм.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» **INFO@ZASAG.CO**
Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ЗАСГИЙН ГАЗАР

Багшийн хөгжлийг дэмжих тогтоол гаргав

Монголын багш нарын VII их хуралд зориулан Засгийн газар баасан гарагт ээлжит бусаар хуралдлаа. Тус хурлаар Багшийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай тогтоол баталсан байна. Тус тогтоолд багшийн ажлыг хөнгөвчлөх, ажиллах орчныг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр зургаан төрлийн ажил хийхээр тусгажээ. Тухайлбал, багш нарын их хурлыг таван жил тутам зохион байгуулах, 2019 оны есдүгээр сараас эхлэн хичээл практикийн ажлын зардлыг төрөөс даах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй жирийн сургуулийн багш нарыг урамшуулах, дээд боловсролын байгууллагын багш нарын мэргэжил дээшлүүлэх төв нээх зэргийг багтаажээ. Түүнчлэн боловсрол, сургалтын байгууллагын багш, ажилтныг



С.Батсайхан / ЗГМ©

жилдээ нэг удаа эрүүл мэндийн үзлэгт оруулахыг Эрүүл мэндийн болон БСШУС-ын сайдад даалгасан байна. Засгийн газрын бас нэг чухал шийдвэр нь тус тогтоолоор Цахим засаглал үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр ЕБС, цэцэрлэг, мэргэжлийн сургалт

үйлдвэрлэлийн сургуулийн багш нарыг компьютероор бүрэн хангахаар болов. Мөн багш нарын VII их хурлаар хамгийн их ярьсан багшийн ажлын байрны нөхцөлийг сайжруулах, үнэлгээг шинэчлэн батлах үүргийг ХНХ-ын сайдад өгч, энэ ондоо багтаан хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.04.15-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТУГ-д шатахуун нийлүүлэх

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/018
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТУГ-д шатахуун нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байх ёстой.
Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендер нь дараах багцаас бүрдэнэ: Багцгүй.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 3 жилийн 2016, 2017, 2018 оны аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.
- **Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт хуулбарыг ирүүлнэ.
- **Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Ижил төстэй ажилд Шатахуун нийлүүлсэн туршлагыг тооцно.
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм**
Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ.
1,800,000 /нэг сая найман зуун мянга/ төгрөг

Тендерийг **2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 11 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй
Дотоодын давуу эрх тооцно.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810



Японы хөрөнгө оруулалттай Инвескор Санхүүгийн байгууллага нь байгуулагдсан цагаасаа эхлэн тогтвортой өсөлттэй байж, Монгол улсын санхүүгийн зах зээлд байр сууриа батжуулан, банк бус санхүүгийн салбарт эргүүлэгч байгууллага болон өсөн дэвжиж байна.

Бид Харилцагч төвтэй үйлчилгээг дээдлэж, тэдэнд зөв, хариуцлагатай санхүүгийн мэдлэг, төлөвшилийг олгох чиглэлийг эрхэм болгон үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ олон улсад танигдсан, орчин үеийн технологийн дэвшлийг нэвтрүүлэгч байхыг зорин ажилладаг.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт 7 салбартай, тэдгээрээр дамжуулан харилцагчдын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн, түргэн шуурхай санхүүгийн үйлчилгээг үзүүлж, санхүү, бизнесийн зөвлөгөө өгч байна.

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ

САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ

- » Санхүү, эдийн засгийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- » Санхүүгийн шинжээчээр 2-оос дээш жил ажилласан туршлагатай;
- » Хариуцлагатай, ачаалал даах чадвартай;
- » Англи хэлний дундаас дээш мэдлэгтэй;
- » Компьютерийн хэрэглээний програмуудыг бүрэн эзэмшсэн;
- » Тогтвор суурьшилтай ажиллах сонирхолтой;
- » Үнэт цаасны компанид ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Та өөрийн анкетаа indra@invescore.mn хаягаар илгээнэ үү.
Зөвхөн анкетийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн кандидат руу холбоо барих болно.

ХОЛБОО БАРИХ
Утас: 7709-0077, 9004-9938
Хаяг: 13 давхар - Твин Таур 1, Сөүлийн гудамж 10/1, 2 хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар

Нийтлэлчийн булан

Нэг өдөрт БНСУ-ын
ЭСЯ-нд виз мэдүүлэгч
монгол иргэдийн тоо

800-1000 хүн

Монгол Улсын
нийт хүн амд
харьцуулсан
хувиар авч үзвэл

Долоо хоногт
0.1%

Сард
0.4%

Жилд
5%

Нэг улсын
иргэд
тухайлсан ганц
улс руу зорчих
визийг ингэж
олноороо
мэдүүлж
буй нь олон
улсад ч ховор
үзэгдэл гэж
Солонгосын
элчингийнхэн
үзэж, толгой
сэгсэрч байна.

Элчинг зүхэхийн оронд эрх баригчдаасаа хариуцлага нэх

**Ард иргэдээ хүний
нутагт хар
ажил хийхээс өөр
сонголтыг эрх
баригчид олгосонгүй**

Энэ мэдэгдлийг Монголын иргэд маш эмзгээр, бухимдалтайгаар хүлээн авсан төдийгүй ийм хандлага зарим хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэлээнээс ч уншиглав.

Тус мэдэгдэлд дурдсанаар Солонгост ажиллаж, амьдардаг Монголын иргэн Хөх ордон /БНСУ-ын төрийн ордон/-ы иргэдийн гомдол хүсэлт хүлээн авдаг буланд Монгол дахь Элчин сайдын яам виз мэдүүлэгтэд дунджаар 70 хоног зарцуулж байгаа нь тус улсын элчингийн дээрэнгүй, нэг улсыг үл ойшоосон хэрэг хэмээн гомдол мэдүүлсэн талаар дурджээ. Гэхдээ энэ нь мэдэгдлийн гол агуулга биш. Харин Солонгосын элчингээс визийн мэдүүлэгт ийм олон хоног зарцуулж буй шалтгааныг тайлбарласан байна.

Тус улс руу зорчих виз мэдүүлж
буй монголчуудын тоо тоймгүй
олон болжээ. Цаашлаад хуурамч
бичиг баримт бүрдүүлэхдээ хүний
санаанд багтамгүй арга заль
хэрэглэх болсныг лүлсэн байна

Үүнд Европын болон дэлхийн бусад өндөр хөгжилтэй орнуудын визийг хуурамчаар

үйлдэн гадаад паспорт дээрээ дарах, нийгмийн даатгалын лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, татварын тодорхойлолт, гэрлэлтийн бүртгэл, төрсний бүртгэлийн лавлагаа, банкны хуулга, таван сая төгрөг байршуулсан гэрээ түрээсийн болон ажлын газрын тодорхойлолт, төрөл садангийн лавлагаа, оюутны тодорхойлолт, малчны тодорхойлолт... гээд байж болох бүхий л бичиг баримтын хуурамчаар үйлдэн, виз мэдүүлж болсон аж.

Тус улсын Элчин сайдын яамнаас өгсөн мэдээллээр БНСУ-д зорчих виз мэдүүлэгч монгол иргэдийн тоо өдөрт 800-1000 байдаг гэнэ. Үүнийг хүн амын тоотой харьцуулж харвал долоохонгог Монгол Улсын нийт хүн амын 0.1 хувь, сард 0.4 хувь жилдээ таван хувь нь зөвхөн БНСУ-руу зорчих хувь мэдүүлэгч өгч байна гэсэн үг. Элчингийнхэн визийн мэдүүлэг хүлээн авах үүрэг бүхий ажилчдынхаа тоог үлэмж нэмэгдүүлээд ч ачаалал маш их байгаа гэнэ.

Нэг улсын иргэд тухайлсан ганц улс руу зорчих визийг ингэж олноороо мэдүүлж буй нь олон улсад ч ховор үзэгдэл гэж Солонгосын элчингийнхэн үзэж толгой сэгсэрч байна.

БНСУ-д хууль бусаар оршин сууж байгаа нийт гадаадын иргэдийн дунд гурван сая хүн амтай монгол иргэдийн эзлэх хувь нь 1.4 тэрбум хүн амтай Хятад

улс, 90 сая хүн амтай Вьетнам улстай адил хэмжээнд буюу сар бүр 500-600 хууль бус оршин суугч шинээр нэмэгдэж байна гэж нэмж өгүүлэв. Энэ мэт үзүүлэлтээр дэлхийн 170 гаруй улсад суугаага БНСУ-ын Элчин сайдын яамдаас Монгол улсад суугаа элчингийнхнээ нэгдүгээр байранд орж байдаг аж.

Үнэхээр энэ бол толгой сэгс-
рэхээс ч аргагүй үзэгдэл. Гэхдээ
ийм олноороо Солонгос явах гэсэн
монголчууд, тэдний визийг богино
хугацаанд гаргаж өгч амжихгүй
байгаа тус элчингийн ч буруу биш.

**Солонгос нь
Монголын
хамгийн том
“ажил олгогч” юм**

Харин монголчуудыг сайхан амьдруула гэж эрх барьчихаад төрийн өндөр албан тушаалын хувийн ашиг сонирхол, баяжих арга, цөлмөх хэрэгсэл болгож буй эрх баригчдын буруу. Ийм мэдэгдэл гаргасных нь төлөө тус улсын Элчин сайдын яамыг буруутгаж хандлагатай сэтгэгдэл бүр тийм агуулаагүй бүхий мэдээлэл мэдээлүүд хэвлээгээр гарч буйг дээр өгүүлсэн. Бид солонгосчуудыг харааж загнан биш гуравхан саяа иргэнээ “Яаж ийгээд хилийн дээс л давчихвал...” гэсэн.

мөрөөдөлтэй болтол, тэгэхийн тулд ямар ч хамаагүй заль мөх сэдэлтэй нь ядууруулж буй төрд гарсан. Лулайварчидтайгаа л тэмцэх хэрэгтэй. Тэднийг ард иргэдийнхээ сайн сайхан амьдралын төлөө чөмгөө дундартал зүтгэдэггүй юмаа гэхэд татвар төлөгчдийн мөнгөнөөс ихдэжгүй байхыг, бизнесийн боомилох биш дэмжсэн бодлого гаргахыг, бизнесмэнуүүдийг шат шатаандаа дарамталж хээл хахууль нэхэхгүй байхыг, жижиг дунд бизнесийг дэмжинэ гэж хэлээд тэрбум тэрбумаар нь хүүгүй мөнгө өөрсдөө авч, буцаагаад жирийн иргэдэд хүүтэй зээлж хүүлэхгүй байхыг шаардах хэрэгтэй.

Ийнхүү иргэд нь өдөрт л мянга мянгаараа гадаад явах хүсэлтээ илэрхийлж, эх орноосоо бараг дайжихад бэлэн байна гэдэг төр засгийг удирдаж буй эрхмүүдийн бодлого, шийдвэртэй шууд холбоотой.

Нөгөө талдаа Монголд ажил бий юу гэвэл тийм. Монголын ажлын байрны төв сүлжээ болсон www.biznetwork.mn сайтад ажилд авах зар ажил хайгчаасаа олон байгаа нь үүний нотолгоо. Хамгийн сүүлд СХД-ийн хөдөлмөрийн хэтгэсээ зохион байгуулсан ажлын байрны өдөрлөг дээр “Нээлтгүй ажлын байрны захяалга маш их байгаа боловч ажиллах хүч, ажил хайж байгаа иргэн алга” хэмээн тус дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга Б.Будмаа хэлж байв.

Тэгэхээр ажил байгаа ч ажлын байрны цаг, нөхцөл таатай бус, эсвэл авсан цалин нь амьдралд хүрдэггүй учраас монголчууд гадаад гарч ажиллах сонирхолтой болчихсон гэсэн үг. Мөн Монголын нийгэм бүхимдэлтай, агаар хөрсний бохирдол их, хууль шүүх, төрийн албаны шударга бус байдал, эрүүл мэнд боловсролын хүртээмж муу гэдэг орноосоо дайжих шалтгаан мундахгүй их юм.

- Тус улс руу зорчих виз мэдүүлж буй монголчуудын тоо тоймгүй олон болжээ.

● “Яаж ийгээд хилийн дээс л давчихвал...” гэсэн мөрөөдөлтэй болтол нь ядууруулж буй төрд гарсан луйварчидтайгаа л тэмцэх хэрэгтэй.

● Баян ядуугийн зааг хэт их алсарсан өнөө үед Монголын багахан дундаж давхаргыг гадаадад байгаа монголчууд л бүрдүүлж байгаа.

Багш нар гурван сарын визээр Солонгосыг зорьж, тэндээ харуулах хандлага их байгаа нь боловсролын салбарт доржилт өгсөн. Харин сүүлийн үед эмч нар эх орондоо ажилласнаар Японд асрагч хийх нь амьдралд нэмэртэй гэж үзэх болсон нь энэ

салбарын эмзэг асуудал болсныг эх сурвалжууд хэлж байгаа. Хамгийн тогтвортой, хувийн хэвшлийг бодвол хөдөлмөрийн нөхцөл хөнгөн, цалин хөлс нь хоцрохгүй, нийгмийн даатгал тасрахгүй энэ мэт төсвийн албан хаагчид хүртэл хүний нутагт яар ажил хийхээр одоо байгаа нь хая аргагүй төрийн бодлогын алдаа.

Солонгосыг гоё, гэмгүй учраас монголчууд зориод байгаа юм биш. Хүний нутагт хүнд хөдөлмөр хийнэ, дээрэлхүүлэн, гадуурхагдана. Заримдаа гэмт хэргийг золиос болно, гэр бүл нь салж сарнина. Гэхдээ монголчуудад хүний нутгийг зорьж хар ажил хийхээс өөр сонголтгүй. Монголын удирдагчид олгосонгүй. Тийм болохоор элчинг зүхсхийн оронд эрх баригчдаасаа хариуцлага нэх, тэмц. Харин ч олон монгол иргэнийг сайхан амьдрахад нь 30-аад жил боломж олгосон тус улсад талархах хэрэгтэй. Яг үнэндээ УИХ, Засгийн газрын гишүүд, хууль хүчний байгууллагын удирдлагууд, мэдээлэл ойр, эрх мэдэлтнүүдэд нөлөөлж чадаж буй хэсгийн амьдрал жирийн иргэдээсээ хэт тасарч одсон өнөө үед Монголын багахан дундаж давхаргыг гадаадад байгаа монголчууд л бүрдүүлж байгаа.

Монголын ядуучууд олон учраас хөгжихгүй байгаа юм биш, дээдчүүл нь цадахгүй байгаа учраас хөгжихгүй байна гэсэн Ерөнхий сайд асан Дашийн Бямбасүрэнгийн үгийг энд дахин дурдъя. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Хороодын доторх авто замын засвар, тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6, 15, 18, 25 дугаар хороо”-ын ажил
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/015

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос **“Хороодын доторх авто замын засвар, тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6, 15, 18, 25 дугаар хороо”-ын ажлыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул **www.tender.gov.mn**, хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45 хоногийн** туршид хүчинтэй байна.

Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, үзүүллийг тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж түүвэлтийг нь тооцох жилийн тоо: (2016, 2017, 2018 он) борлуулалтын дундаж орлого нь төсөвт өртөгийн 30 хувийс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2016, 2017, 2018 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2016, 2017, 2018 оны аль нэг жилд төсөвт өртгийн 40 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм
Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд нотариатаар
гэрчлүүлэн ирүүлнэ.

Зам, тээврийн яамнаас олгодог:

2.8.1.3 Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах
Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнас олгодог:

ЗТ сайдын 2013 оны 152 дугаар тушаалаар батлагдсан журмын
1.6 3Б-1-6 /3км хүртэл/ үүнээс дээш эсвэл,
ЗТБХБ сайдын 2010 оны 47 дугаар тушаалаар батлагдсан журмын
2.8.1 Хатуу хучилттай зам барих эсвэл,
ЗТ сайдын 2018 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан журмын
2.8.2.1 Хатуу хучилттай зам барих

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. **25,000,000 /хорин таван сая/ төгрөг**
Хүчинтэй байх хугацаа: **2019 оны 07 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хүчинтэй байна.**

Тендерийг **2019 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 14 цаг 40 минутаас өмнө** системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн 14 цаг 50 минутад** Нийслэлийн Худалдаан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер **ирүүлэх эрхгүй.**
Дотоодын давуу **эрх тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810

Шинжлэх ухаан



ЭСИЙГ УНТУУЛАХ АРГААР ӨВДӨЛТИЙГ НАМДААНА

Жейм Галлахер

Эмч нар “эсийг унтуулдаг” шинэ төрлийн эмээр хурц өвдөлт мэдэрдэг өвчтөний зовниург намдаах боломж бүрдэж байна. Порфирины дутагдлаас үүсдэг үе үе хүчтэй өвдөх буюу зарим тохиолдолд үхэлд хүргэдэг ховор өвчнийг мөн намдаах боломж нээгдэв. Шинэ арга нь хүний ДНХ дэх генийн ажиллагаанд “сайнаар” нөлөөлөхөд суурилжээ. Эмч нар энэ аргын үр дүнг үнэхээр гайхамшигтай хэмээн үнэлээд урьд эмчилгээгүй гэж үзэж байсан өвчнүүдэд хэрэглэж болохыг тэмдэглэв.

Британийн Норфолк хотын Сью Баррелл бусад хүмүүс төсөөлөхийн ч аргагүй өвдөлтийг, мэдэрч, өдөр бүр опиоид уудаг байлаа. Түүнд илэрсэн порфири өвчин хоёр долоо хоногт нэг удаа давтагдаж, эмнэлэгт авчрахаас өөр аргагүй болдог. Гэтэл өвчин даамжирсаар морфин уугаад ч нэмэргүй болов. Тэрбээр BBC-

ын сурвалжлагчид ярихдаа “Өвдөлт хүүхэд төрүүлэхээс хүчтэй мэдэгддэг. Хөл, нуруу гээд бүх бие янгинана. Үнэхээр тэсвэрлэхийн аргагүй” хэмээн ярьсан байна. Түүний дүү ижил өвчтэй учир бүрэн чадваргүй болж, эмнэлэгт байнгын асаргаанд байдаг аж.

Порфирийн хэд хэдэн төрөл байх агаад хүний биеэр хүчил-төрөгч тараадаг цусны улаан эд дэх гемоглобины нэг агууламжийн дутагдлаас үүсдэг өвчлөл юм. Үүний улмаас Сьюд хүчтэй өвдөлт өгдөг байна. Зарим порфири арьсны өвчлөлийн хэлбэрээр илэрнэ. Сью эмийн туршилтад оролцож, одоо ч эмээ уусаар байгаа. Тэрбээр “Амьдрал маань бүрэн өөрчлөгдсөн. Би 10 жил өвдөлт мэдэрч, хаашаа ч зугтах аргагүй гэж боддог байв” гэсэн юм.

Вена хотод болсон Олон Улсын элэгний конгресс дээр 18 орны 94 өвчтөнд явуулсан

туршилтын үр дүнг танилцуулсан байна. Эмчилгээний дараа хурц өвдөлтийн давтамжийг 74 хувиар бууруулжээ. Өвчтөнүүдийн 50 хувьд эмчилгээ шаардлагатай өвдөлт бүрэн арилсан байна. Нэг хүн давхар нөлөөний улмаас туршилтаас гарчээ. Энэ эмчилгээнд “Эсийг унтуулах” гэдэг аргыг ашигладаг. Эс бол гормон, энзим буюу генетикийн эдийг бүрдүүлдэг уургийг агуулдаг ДНХ-ийн нэг хэсэг юм. Givosiran гэдэг нэртэй эм энзимийн түвшинг бууруулж, хортой уураг үүсгэхээс сэргийлснээр өвдөлтийг намдаадаг байна. Лондоны хааны коллежийн профессор Дэвид Рииз Британид туршилтад оролцсон өвчтөнүүдийг эмчилжээ. Тэрбээр “Энэ бол асар чухал эмчилгээ. Маш шинэлэг. Порфирийн нөхцөлд анх удаа амжилттай туршлага” хэмээн өгүүлэв. Тэрбээр уг амжилтад гайхсанаа илэрхийлээд хүмүүст

ихээхэн найдвар төрүүлж буйг онцоллоо. Энэ аргаар өөр өвчнийг эмчлэх боломж бий юу гэдэг асуулт гарах нь дамжиггүй. Тийм гэж хариулж болох авч нэлээд эрт байгааг эмж нар анхааруулав. Эсийг унтуулах аргаар сэтгэцэд нөлөөлдөг удамшлын өвчнийг эмчилсэн туршлага бий. АНУ-ын Хүнс, эмийн захиргаа энэ төрлийн эмийг “Анагаах ухаанд шинэчлэл хийх боломжтой” хэмээн үнэлсэн.

Гэхдээ энэ бол эсийн эмчилгээ учир алдаа гаргаж, өөр кодыг өөрчилбөл буцаах аргагүй. Эсийг унтуулах арга генд нөлөөлдөггүй боловч түүнээс дамжуулах дохиог онилдог. Ийм эрсдэлээс гадна генетикийн эмчилгээ асар өндөр өртөгтэй. Саяхан хараа оруулах нэг удаагийн эсийн эмчилгээний үнэ 85000 ам.доллар болж байв. Givosiran эмийн сарын тун ямар үнэтэй нь тодорхой бус байгаа. Гэвч энэ салбар хөгжиж, өртөг эцэстээ буурна гэж найдах л үлдлээ. [ЗГМ]

Тархийг идэвхжүүлэх замаар залуужих боломжтойг нотлов

Бостоны их сургуулийн эрдэмтэд тархийг цахилгаанаар зөөлөн идэвхжүүлэхэд 60-аас дээш насны хүмүүсийн танин мэдэхүйн чадамж, тухайлбал ой санамжийг 20 насныхны түвшинд авчирч болно хэмээн баталж байна. Уг судалгаанд 20 настай 42, 60-70 настай 42 хүн сайн дураар оролцжээ. Тэдний дунд төстэй хоёр зургийг хэдхэн секунд ажиглаж, ялгааг олох ой санамжийн сорилт явуулсан байна. Ингэхдээ насны бүлгүүдэд тархины идэвхжилийн ажилбарыг хуурамч, жинхэнэ хоёр янзаар хийжээ.

Жинхэнэ идэвхжилийн дараа 50 минутын дотор хөгшчүүлийн бүлгийнхэн сорилтыг залуусын адил давж байгаа нь ажиглагдав. Харин хуурамч ажилбарын дараа

ялгаа гараагүй байна. Эрдэмтдийн ярьснаар цахилгаан идэвхжилийн нөлөө таван цаг ба түүнээс дээш хугацаанд үргэлжилдэг аж. Толгойд нягт өмсгөсөн малгайд залгасан электродоор дамжуулан цахилгаан гүйдэл өгсний дээр оролцогч бүрийн тархины долгионыг хэмжсэн байна.

Үүний үр дүнд тархины урд хэсэг ба чамархайн хэсгийн нейроны идэвхжилийг синхрон болгожээ. Эрдэмтдийн ярьснаар настай хүмүүсийн тархинд синхрон чанар алдагдсанаас ой санамж мууддаг байна. Уг туршилтыг одоохондоо ямар нэг практик үйл ажиллагаанд ашиглаагүй бөгөөд зөвхөн эрдэм шинжилгээний зориулалттайг судлаачид онцлов. [ЗГМ]



Сармагчин дээр хийсэн туршилтаас үзэхэд согтууруулах ундаа хэрэглэх нь хүүхдийн тархинд муугаар нөлөөлөөд зогсохгүй өсөлтийг удаашруулдаг аж. Eneuro сэтгүүлд өгүүлсэн нийтлүүлсэн эрдэмтэд ийм дүгнэлт танилцуулсан байна. Орегон муж улсын Портлэнд дахь Анагаах ухааны их сургуулийн профессор Кристофер Кронке “Ийм судалгаанууд гол төлөв согтууруулах ундаа уудаг хүүхдүүдийн өөрсдийнх нь арианд суурилсан байдаг. Харин манай туршилт согтууруулах ундаа тархины өсөлтийг сааруулдаг гэсэн эргэлзээгүй дүгнэлт хийж, шалгалаа” хэмэв.

Сүүлийн жилүүдэд эмч нар урт хугацаагаар архи хэрэглэх нь элэгний цирроз, тархины үйл ажиллагаа төдийгүй бусад маш хүнд үр дагаварт хүргэдгийг нотолсоор байгаа. Жишээ нь, хоёр жилийн өмнө спиртийн хэт хэрэглээ долоон төрлийн хорт хавдраас гадна бие дэх азотын ислийн эргэлтийг тасалдуулж, уушгины ажиллагаанд бэрхшээл үүсгэдгийг нотолсон. Дээр нь бага хэмжээний архи хүртэл ой санамжийн төв болон тархины бусад хэсгийг хатаадаг шинж тэмдэг үзэгдсэнийг илрүүлжээ.

Кронке болон түүний баг дээрх үзэгдэл архинд эмзэг хүүхэд, залуусын тархинд хэрхэн нөлөөлдгийг сонирхсон байна. Үүний тулд 3-5 настай 60 макака сармагчин авчруулжээ. Судлаачид тэднийг хоёр төрлийн ундаатай тусгай торонд суулган тархины

зургийг авсан байна. Нэгд нь цэвэр ус, нөгөөд нь дарс буюу шар айрагтай дүйхүйн спиртийн ханд тавив. Согтууруулах ундааны амт авсан сармагчинд хагас жилийн хугацаанд дуртай хэмжээгээрээ уух боломж олгожээ.

Үе үе ундааны агууламж ба тархины өөрчлөлтийн зургийг авч, хэмжээ ба бусад шинж чанарыг өмнөхтэй нь харьцуулав. Энэхүү өгөгдлөө цэвэр ус уусан бүлгийнхтэй мөн жишиж үзсэн байна. Эдгээр харьцуулалт эрдэмтдийн сэжиг таамгийг нотолж, өдөрт 4-5 аяга шар айрагтай тэнцэх спиртийн илүү агууламж тархины хэмжээ өсөхөд илт саад учруулж, уудаг сармагчны хөгжилд олон зөрчил үүсгэдгийг илрүүлжээ. Уусан спиртийн грамм бүр жилдээ мэдрэлийн эдийн өсөлтийг 0.25 шоо сантиметрээр багасгадгийг тогтоов.

Энэхүү өөрчлөлт ой санамжийн төв, тархины гүн дэх санамжийг хадгалж, мэдээллийг хуваарилдаг цагаан эд ба таламусын хөгжилд сөрөг нөлөөтэйг мэдрэлийн систем судлаачид илрүүлээ. Их уусан макака сармагчны тархины өсөлт 70 хувиар, дунд зэрэг уусных нь 50 хувиар удааширсан гэж тооцжээ. Сонирхолтой нь спиртийн ундаа уухаа болиход тархи буцаад хэвийн байдалдаа түргэн орсон байна. Эрдэмтэд үүсэх асуудлаас сэргийлж чадах эсэхийг судлаагүй агаад макака дээрх дараагийн туршилтаа үүнд зориулахаар төлөвлөжээ. [ЗГМ]



ДОХ шумуулын хазалтаар дамждаг уу

Судалгаанаас үзэхэд оросуудын зургааны нэг нь ДОХ-ын вирус шумуулын хазалтаар дамжина гэдэгт итгэдэг аж. Росстат байгууллага 2018 онд бүх бүс нутгийг хамарсан 15000 гэр бүлийн дунд санал асуулга явуулж ийм дүгнэлтэд хүрсэн байна. Судалгааны дүнгээс харахад оролцогчдын 17 хувь нь шумуул ДОХ дамжуулдаг гэдэгт итгэдэг байна. 20 хувь нь мэдэхгүй, 11 хувь нь ДОХ-той хүнтэй хоол хувааж идвэл халдварлана гэсэн бол 14 хувь эргэлзэж байгаагаа илэрхийлжээ.

Гэхдээ хүмүүсийн тал хувь нь ДОХ жирэмслэлт, төрөлт ба хөхүүлэх үед эхээс нярайд дамждагийг мэдэж байв. Оросын холбооны ДОХ-той тэмцэх ба

сэргийлэх төвийн удирдагч академич Вадим Покровский иргэд энэ өвчлөлийн талаар бага мэдлэгтэй байгаа нь цааш тархахад нөлөөлж буйг анхааруулав. Тэрбээр хамгийн найдвартай хамгаалах арга бол бэлгэвч хэмээн тодруулаад шумуулын хазалт, ус, хоол, агаараар дамжих боломжгүйг тайлбарлалаа.

ДОХ-той тэмцэх холбооны төвийн мэдээгээр 2018 онд ОХУ-д сая гаруй иргэн ДОХ-ын халдвартай байна. Дээр нь 300-500 мянган хүн өвчтэй гэдгээ мэдэхгүй байгаа гэж Покровский үзэж байна. ДОХ-ын халдвар хамгийн өргөн тархсан бүс нутагт Кемеров, Эрхүү, Свердловск, Самар, Оренбург муж багтаж байгаа юм. [ЗГМ]

Юу идсэн бус юу идээгүйд их учир бий

Вашингтоны их сургуулийн анагаахын профессор Ашкан Афшин “Олон оронд муу хоол хүнс тамхи, даралтаас илүү үхлийн шалтгаан болж байна” хэмээн бичжээ. Гэхдээ хүмүүс улаан мах, хийжүүлсэн чихэртэй ус гэх мэт эрүүл бус хүнсийг сонгож байгаад бус харин эрүүл хүнс дутагдаж байгаад учир нь оршдог аж. “Lancet” сэтгүүлд тайлан нь нийтлэгдсэн судалгааны багийн ахлагч Афшин бас хэт давстай хүнс хортойг онцлов.

Тэрбээр “Энэ асуудлаар уламжлалт хэлэлцүүлэгт эрүүл бус хүнсийг голлон анхаарч ирсэн бол бидний судалгаа нийт хүн амын түвшинд эрүүл хүнсийг хангалттай хэмжээгээр хэрэглэхгүй байгаа нь хорт хүнс хэрэглэснээс илүүтэйгээр үхлийн шалтгаан болдгийг харууллаа” хэмээн ярьсан байна. Судалгаанаас үзэхэд 2017 онд цаг бус таван үхэл тутмын нэг нь буюу 11 сая хүн давс хэтрүүлсэн болон бүхэл үр, жимс, самар, ногоо дутмаг хэрэглэснээс болж нас барсан нь транс тос, чихэрлэг ундаа, улаан махнаас шалтгаалсан үхлээс давжээ. Судалгаанд оролцсон Шинэ

ХҮНСТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Билл ба Мелинда Гейтс нарын сангаас санхүүжүүлсэн уг ажлын хүрээнд Афшины баг хүнстэй холбоотой 15 эрсдэл ба тэдгээр нь нас баралт, хөгжлийн гажуудалтай хэрхэн уялддагийг судалсан байна. Ашигтай бус улаан мах, түүгээр хийсэн хоол, чихэрлэг ихтэй ундаа, транс тосны хүчил болон давс агуулсан хүнсний нөлөөг ашигтай хүнсний дутмаг хэрэглээтэй жишиж үзсэн байна. Ашигтай хүнсэнд жимс, ногоо, бүхэл үр, сүү, калыци, самар, өөхний хүчил, далайн хүнсий Омега-3, шош, мяндаслаг ургамал, ханасан биш өөх, ургамлын тос, ашигтай тос зэргийг багтаажээ.



[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэл сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энжааргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
ЗАР СУРТАЛЧИЛГАА
Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zg.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

86580004029112

001121

Би үйлдвэрлэгч



Ж.Гэрэлчулуун / ЗГМӨ

Дотоодын шоколадны хэрэгцээг хангах зорилготой Sayan брэнд

Албан байгууллага болон хувь хүмүүсийн захиалгаар шоколадаа хийдэг

Г.Санжааханд
ЗГМ

“Хайраар урласан Монгол амт” уриатай “Заан фүүдс” ХХК-ийн Sayan брэндийг “Би үйлдвэрлэгч” буландаа онцолж байна. Европын дээд зэргийн шоколадны түүхий эд, итали технологи, тоног төхөөрөмж ашиглан Монголдоо анх удаа гар аргаар хийдэг шоколадыг Sayan брэндийн хамт олон өөрийн өвөрмөц жорын дагуу 100 хувийн байгалийн түүхий эдээр хийж хэрэглэгчдэдээ хүргэж эхэлснээс хойш нэг жилийг үджээ. Энэ хугацаанд гадаад болон дотоодын олон хэрэглэгчтэй болж, хүмүүст хэдийнэ танигдаж эхэлсэн байна. Тухайлбал, энэ брэндийн эрхэм хүндтэй хэрэглэгч нь Төрийн ёслолын алба. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий Сайд, УИХ-ын дарга нарын гадаад, дотоод айлчлал, хүлээн авалт, бэлэг сэлт зэрэг олон нарийн чимхлүүр ажлыг хариуцдаг төрийн дипломат алба эднийхээр үйлчлүүлдэг. Мөн Sayan шоколадыг үйлдвэрлэж эхэлсэн цагаас эхлэн өнөөдрийг хүртэл олон улсын байгууллагууд, гадаад дотоодын нэр хүндтэй компаниуд бүтээгдэхүүнийх нь амт чанарыг өндрөөр үнэлэн, тогтмол захиалсаар иржээ.

ЖДУХС-ГААС ЗЭЭЛ АВЧ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨ НЭМЭГДҮҮЛЖЭЭ

Артизан шоколад гэдэг нь handcrafted буюу гар аргаар хийгдгээрээ бусдаас ялгардаг. Энэ нь цэвэр органик бүтээгдэхүүн учир ямар нэг хугацаа уртасгагч юм уу амт оруулагч, химийн бодис нэмдэггүй, зөвхөн байгалийн гаралтай түүхий эд хэрэглэдэг аж. Амт чанар сайнаас гадна



Албан байгууллага, хувь хүмүүсийн захиалгаар компанийн болон арга хэмжээний лого бүхий хайрцагтай шоколад захиалгаар хийдэг байна. Дотроо төрөл бүрийн амттай бөгөөд дөрөв, ес, 16 ширхгээр хийлгэх боломжтой аж.



эрүүл мэндэд хоргүй, органик бүтээгдэхүүн тул хадгалалтын хугацаа арай богино буюу 3-6 сар байдаг аж. “Энэ нь органик бүтээгдэхүүн гэдгийг илтгэж байгаа юм” хэмээн Sayan брэндийн захирал З.Болормаа хэлсэн юм. Тэрбээр тус брэндийг нөхөртэйгөө хамтран үүсгэн байгуулж, гэр бүлийн бизнес болгосон байна. З.Болормаа нь банк санхүү болон худалдааны чиглэлээр олон жил ажиллажээ.

Харин түүний гэр бүлийн хүн болох Ж.Буд-Эрдэнэ нь маркетингийн чиглэлээр ажилладаг. Анх үндэсний хэлбэр дүрстэй шоколадны дизайн, хэв маяг гарган гадаадын шоколадны үйлдвэрт захиалах санаа төрж, Бельги, Польш, Эстонийн шоколадны үйлдвэрүүдэд захиалгаар, ямар үнэ өртөгтэй хийх талаар судалж эхэлжээ. Тэдгээр үйлдвэрлэгчид асар их хэмжээгээр, бас үнэтэй үйлдвэрлэх нөхцөл тавьсан байна. “Монгол шоколадыг гадаадад үйлдвэрлээд оруулж ирнэ гэхээр утгагүй санагдаж, бид яагаад дотоодоо үйлдвэрлэж болдоггүй юм гэж бодсон.

“996 ажиллах боломж гэдэг бол аз жаргал” хэмээн Хятадын тэргүүн баян мэдэгдэв. “Alibaba-д ажилламаар байгаа л бол өдөрт 12 цаг ажиллахад бэлдэх хэрэгтэй. Чадахгүй бол түвэг удах хэрэггүй”.

Ажлын урт цаг, стрессийн улмаас цаг бусаар гэнэт өөд болсон програмчлагч, стартапуудын тухай ам дамжсан яриа Хятадын технологийн салбарт их тул Жэк Магийн мэдэгдэл нэн даруй шуугиан дэгдээлээ.

“Огтоос утга алга. Хэрвээ 996 хуваарин ажиллавал компани илүү цагийн хөлс олгох уу гэдгээ

ч цухуйлгасангүй. Хувийн учир шалтгаанаа бус, хууль журмаа мөрдөж байгаасай” хэмээн Weibo-д нэг нь тайлбар бичжээ.

“Босс 996 хүсээд байгаагийн учир нь өөрсдийнхөө эд баялгийг л арвижуулах гээд байгаа хэрэг” хэмээн өөр нэг нь шүүмжлэв. “Илүү цагийн хөлсгүй 996 ажиллуулж мөлжих санаатай”.

Тайлбар хүссэн хүсэлтэд Alibaba-гийн төлөөлөгч хариу өгсөнгүй.

Жэк Магийн тайлбар онлайн ертөнцөд ширүүн маргаан дэгдээлээ. Хятадын програмчлагчид хөдөлмөрийн нөхцөлөө эсэргүүцэж буйн илрэл болгон гуравдугаар сард код шерингийн Github сайтад 996.ICU баннер байршуулсан нь тэр дороо алдаршиж 211 мянган “од”-той болжээ.

Хөдөлмөрийн 996 горимд захирагдвал өөрийгөө ICU буюу эрчимт эмчилгээний өвчтөн болгох эрсдэлтэй” гэсэн тайлбар 996.ICU төслийн хуудаснаа бичээтэй. Ажилтнуудаа цалин нь тооцолгүйгээр урт цагаар ажиллуулдаг байгууллагуудын жишээг ахиу байршуулахыг уг төслийг санаачлагч технологийн салбарт ажиллагсад уриалжээ. Уриалгын дагуу оруулсан жишээнд Alibaba болоод санхүүгийн салбар дахь Ant Financial-ын нэр байгаа юм.

ТОХИРОЛЦОЖ ЧАДАХГҮЙ БОЛ ТОРГУУЛЬ ХҮЛЭЭЖ БУЙГ МНУЧИН САНУУЛАВ

Эндрю Майеда

Хятадтай худалдааны асуудлаар тохиролцож чадахгүй бол АНУ-д өөрт нь ч хохиролтойг Сангийн сайд Стивен Мнучин анхааруулсан нь хоёр тал хоёул хэлэлцээр байгуулах чин эрмэлзэлтэйн нотолгоо болов. Хэлэлцээрт АНУ, БНХАУ тус тусын хүлээсэн үүрэгтэйг Мнучин бямба гарагт Вашингтонд болсон Олон Улсын Валютын Сангийн хуралдааны үеэр сэтгүүлчдэд анхааруулсан юм. “Албадлагын механизм хоёр талд ижил үйлчилнэ гэж би хувьдаа ойлгож байгаа. Бид хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой. Биелүүлэхгүй бол аль аль талдаа хохиролтой” хэмээн Стивен Мнучин тайлбарлав.

ШҮРЭН ХЯСАА БҮРМӨСӨН МӨХӨХДӨӨ ТУЛААД БАЙНА

Крис Бурк

Нүүрсний цахилгаан станцуудыг хаах зэрэг эрс арга хэмжээ авахгүй бол Австралийн нэрийн хуудас болсон Great Barrier Reef буюу Их саадат шүрэн хясаа бүрмөсөн мөхөхдөө тулаад байгааг засгийн газрын агентлагийн тайланд тулгуурлан Sydney Morning Herald сонин мэдээлэв. Манай гараг дахиад цельсийн 0.5 градусаар дулаарвал шүрэн цохионуудын сүлжээ сүйрнэ гэсэн дүгнэлтийг Австралийн засгийн газрын агентстваас гаргасан судалгааны тайланд дурджээ. Австрали нь Их саадат шүрэн хясааны сүлжээ зэрэг байгалийн гайхамшиг олонтой боловч эдийн засаг нь уул уурхай, олборлодог түлшнээс хамааралтай.

ХӨХНИЙ СҮҮНИЙ НАЙРЛАГАД БАЙДАГ ОРЦ НАСАНД ХҮРЭГСДИЙН ШИНЭ ТЭЖЭЭЛ

DowDuPont Inc, BASF SE зэрэг химийн аварга концернууд хөхний сүүний найрлагад байдаг ходоодонд шингэдэггүй сахарын үйлдвэрлэлд сая сая ам.долларын хөрөнгө оруулж эхэллээ. НМО (Human Milk Oligosaccharide) буюу хүний сүүний олигосахарид нь хөхний сүүний найрлагад хэмжээгээрээ лактоз, өөх тосны дараа гуравдугаар ордог. Уг бодис нь ходоодон дахь ашигтай бактерийн тэжээл болж, дархлаа сайжруулдаг. Nestle SA зэрэг хүүхдийн тэжээл үйлдвэрлэгч компаниуд хиймлээр гаргаж авсан НМО бүхий насанд хүрэгсдийн нэмэлт тэжээлийн үйлдвэрлэл ойрын ирээдүйд нэг тэрбум ам.доллараар хэмжигддэг болно хэмээн тооцоолжээ.

Дэлхийн эдийн засаг уруудах аюул хэвээр байгааг Япон анхааруулав

Такэо Юкүо

Дэлхийн эдийн засаг түнэр харанхуйгаас гарч хараахан амжаагүй байгааг G20-ийн уулзалтыг тэргүүлж буй Япон улс анхаарууллаа.

“Дэлхийн эдийн засаг 10 дугаар сар таамагласнаас арай аажуу эрчтэй тэлж байгаа”-г Японы сангийн сайд Асо Таро баасан гарагт Вашингтонд хуралдсан G20-ийн Сангийн сайд, төв банкны удирдлагуудын хэвлэлийн хуралдаан дээр мэдэгдсэн юм.

Энэ жил G20-ийн хуралдааныг анх удаа тэргүүлж буй Япон улс олон улсын татварын шинэ зохицуулалтаас эхлээд дэлхийн худалдааны тэнцвэргүй байдлыг арилгах хүртэлх олон асуудлаар тодорхой хэлэлцээр байгуулахыг эрмэлзэж байна. Дэлхийн эдийн засаг оны сүүлийн хагаст сайжирч болзошгүй гэсэн Олон Улсын Валютын Сангийн таамагтай 20 гишүүн улс бүгд санал нийлсэн ч тодорхой бус нөхцөл манай гарагийг нийтэд нь хамарч



BWM©

байгааг Япон улс сануулж байна.

“Худалдааны зөрчил гүнзгийрч, бодлого бүрхэг болж, геополитикийн эрсдэл ихсэн, санхүүгийн нөхцөл гэнэт хурцдах аюул байсаар байгааг бид санах ёстой” хэмээн Асо Таро анхаарууллаа.

Их Британи Европын Холбооноос гарах асуудлыг өнгөрсөн долоо хоногт түр шийдвэрлэсний дүнд эрсдэл

нэгээр цөөрсөн ч худалдааны зөрчил, Хятадын эдийн засгийн удаашралын бэрхшээл шийдэгдээгүй хэвээр. Японы хувьд хэлэлцээнээ зайлсхийж өнгөрөөсөн хоёр жилийн эцэст Трампын засаг захиргаатай нүүрэлдэх яриа өрнүүлэх цаг тулаа.

Эрсдэл цаашид ихсэх тохиолдолд гишүүн улсууд хамтын хүчээр бодлого тодорхойлох

шаардлагатайг Японы төв банкны тэргүүн Күрода Харүхико сануулсан юм.

“Ночтой эрсдэл, худалдааны зөрчлийг оролцуулаад бодлогын тодорхой бус, бүрхэх нөхцөл цаашид ч үргэлжлэх төлөвтэй. Компаниудын нөхцөлөөс шалтгаалаад дэлхийн эдийн засаг улам муудах эрсдэл байсаар байгаа”-г Күрода анхааруулж байна.

Эдийн засаг




Шелли Хаган

Шарсан буюу чанасан өндөг дэлхийн хэмжээнд өглөөний хоолны салшгүй хэсэг байсаар ирсэн. Гэвч үнэ болон хүртээмжийн хувьд газар бүрд өөр байна. Лос Анжелес болон Швейцарын санхүүгийн нийслэлийн оршин суугчид өглөөний хоолыг хялбархан олдог бол Египет ба Сахарын цөлөөс доош Африкийн орнуудад өдрийн анхны хоолныхоо мөнгийг олохын тулд илүү урт ажиллах хэрэгтэй.

Bloomberg-ийн дэлхийн хотуудын өглөөний хоолны индексийн сүүлийн жагсаалтад аяга сүү, нэг өндөг, хоёр зүсэм талх болон багахан жимс худалдан авах үнэ ба хугацааг жишиж үзсэн байна. Үүнд 100 гаруй хотын хэрэглэгчдийн өгөгдлийг тусгасан Numbeo.com сайтын өнгөрсөн арванхоёрдугаар сарын үнийг ашиглажээ. Женев, Дубай, Люксембург, Берн дөрөвхөн хотод өглөөний хоолны үнэ өдрийн орлогын нэгээс доош хувьтай тэнцэж байв.

Харин Африкийн Аккра, Лагос хотын иргэд ижил хүнс авахын тулд өдрийн орлогынхоо дөрөвний нэгийг зарцуулах

Өглөөний цай Швейцарт хамгийн хямд, Африкт үнэтэй



хэрэгтэй болдог. Bloomberg дэлхийн үнийг жишихийн тулд түгээмэл хэрэглэдэг дөрвөн

төрлийн хүнсний үнийг авч үзсэн. Гэхдээ Мехикод өндөг, төмс, Шанхайд гахайн шарсан

мах, Кайрт жигнэсэн буурцаг гэх мэтээр янз бүр. 2017 оны индекстэй харьцуулахад Швей-

царт үндсэн орлого хүнсний үнээс түргэн өссөн тул эндхийн иргэд өглөөний зоогийн мөнгөө хамгийн хялбархан олдог болжээ. Томоохон хотуудын дунд Америкийн Сан Франциско, Бостон, Хьюстон хотууд хамгийн хямд өглөөний хоолтой агаад Майами, Филадельфи хотууд доогуур жагссан байна. Ноён Жак Магийн Alibaba компанийн төв оршдог Ханжоу хот Хятадын таван том хотоос хамгийн үнэтэй нь байна. Тус улсад өглөөний хоол идэхийн тулд дунджаар 30 минут ажиллах хэрэгтэй.

Дэлхийд хамгийн үнэтэй буюу 4.45 ам.долларын үнэтэй өглөөний цай Бермудын Хамилтон хотод байдаг ба өмнөх индексийн 3.48 ам.доллараас бараг нэгээр өсжээ. Эндхийн хүн амын хоёр хувь нь ХАА-д ажил-

ладаг ба хүнснийхээ ихэнхийг импортоор авдаг аж. Өглөөний хоол хамгийн хүртээмжгүй 30 хот Өмнөд Америк, Зүүн Европ, Зүүн Өмнөд Ази, Африкт байдаг. Энд түүнчлэн хүнсний аюулгүй байдал сул, тэжээллэг чанар муу учир өвчлөл, тэр ч бүү хэл үхэлд хүргэх эрсдэлтэй.

Өглөөний хоолны хүртээмж хамгийн доогуур Аккра, Лагос хоёр хотын иргэд өдрийн эхний хоолоо худалдан авахын тулд хоёр цаг ажиллах ёстой. Хэрэв Венесуэлийн Каракас хотыг индексэд оруулсан бол бүр ч гашуун дүр зураг гарах байсан байх. Вашингтоны Стимсоны төвийн ажилтан Иоханна Менделсон “Каракасын олонх хүмүүс өглөө, өдөр, оройн хоол гэсэн ойлголт байхгүй. Тэд таваг хоолны мөнгө яаж олох вэ гэж л боддог” хэмээн тайлбарлав.

Шарталт эмчлэх бизнесийг баячууд цэцэглүүлдэг



Шарталт зөвхөн төлбөрийн чадваргүй хүмүүсийн зовлон хэвээр үлдэж байна.

Хэйли Воллер

Эллигийн хувьд шарталтын бизнес нь урагштай байгаа. Нью-Йоркийн сувилагч эмэгтэй “Хэдж” сангийн оффис, зочид буудлын тансаг өрөөнд давсны уусмал, амин дэм болон бусад эмтэй шингэн барин очиж, урд шөнийн уултаас үлдсэн зовиурыг арилгах үйлчилгээ үзүүлдэг. NutriDrip компанид ажилладаг Элли тэрбумтан, загвар өмсөгч, хөгжим, спортын одуудтай ажилладаг учир нууцлалын гэрээтэй агаад овгоо бичүүлэхээс татгалзав. Тэрбээр “Миний дугаар тэдэнд байдаг учир шууд над руу залгадаг. Намайг маш найдвартай хүн гэдгийг тэд мэддэг” хэмээв.

Эмнэлгээс гадуур шингэн хийлгэхийг тансаглал гэж үздэг байсан бол одоо Нью-Йорк, Лас Вегас, Лондон, Дубайд түгээмэл үйлчилгээ болоод байна. Архи болон бусад шалтгаанаар шингэн алдсан хүмүүст гэрт нь, буудлын өрөө, тусгай автобусанд дусал залгах сувилагчид бэлэн байдаг болжээ. Тэд газар сайгүй үзэгдэх болов. Шарталт зөвхөн төлбөрийн чадваргүй хүмүүсийн зовлон хэвээр үлдэж байгаа гэнэ.

Нэг удаагийн ийм эмчилгээ хэдэн зуун ам.долларын үнэтэй.

Уг үйлчилгээг үзүүлэгчдийн тоо олширч, дусал хийхийг чинээлэг байдлын бэлгэдэл мэтээр сурталчилж байна. Үнэхээр ч төлөх чадалтай бол яагаад зовох ёстой гэж. АНУ-ын Хүнс, эмийн захиргаа уг үйлчилгээг бид зохицуулахгүй гэхээс өөр тайлбар өгсөнгүй. Гэвч эмч нар дусал хийх нь шарталтад үр дүнтэй эсэхэд эргэлздэг.

Өнгөрсөн онд Холбооны худалдааны комисс ийм төрлийн бизнес эрхэлдэг iV Bags компани дуслыг хорт хавдар, зүрхний шигдээст сайн хэмээн сурталчилсан учир хариуцлагад татсан. Эднийх одоо үйлчилгээгээ шингэн нөхөх хэмээн сурталчилж байгаа ба шарталтад дусал хийхийг комиссоос хориглоогүй байна. Жүжигчин Гвинет Пэлтроугийн вэбсайтад дусал хийдэг компаниудыг “хордлого тайлах, гоо сайхан, дархлаа, чадавх сайжруулах үйлчилгээтэй” хэмээн бичжээ.

Гэхдээ тэдгээрийн олонх нь шарталт арилгах эмчилгээ хийдэг аж. Жишээ нь, Лондоны Ned зочид буудлын өрөөнд дуудлагаар шингэн нөхөх дусал хийлгэхэд 200 ам.доллар, чалх сайжруулахад 260 ам.долларын үнэтэй. iV.Docs компани өглөө

сэрээд орноос босоогүй байхад дусал хийх үйлчилгээг 249 ам.доллараар санал болгож байна. Дуслын шингэнд толгой эргэх, бөөлжис цутгах, зүрхний цохилт түргэсэхээс сэргийлдэг эмүүд хийдэг аж.

2012 онд өвчин намдаагч эмч Жэйсон Бурке 80 мянган ам.долларын автобус худалдан авч, дусал хийхээр тоноглоод “Шарталтын аврал” хэмээн нэрлэснээс хойш дусал хийх бизнес олон нийтийн анхааралд өртсөн юм. Тэрбээр эхлээд Нью-Йоркт ирэх төлөвлөгөөтэй байсан авч Син хотод ашигтай байсан тул тэндээ үлджээ. Буркегийн вебсайтад гурван төрлийн шарталтын эмчилгээг 349 ам.доллараар санал болгодог.

Тэрбээр өндөр даралттай болон зүрхний цохилт 120-оос дээш гарсан хүнд дусал хийхээс татгалздаг гэнэ. Зарим эмч нар дулаар эмчлэхийн хязгаарлалтыг хүлээн зөвшөөрдөг. NutriDrip компани 18-аас доош ба 75-аас дээш насны хүмүүст үйлчилгээ үзүүлэхээс түдгэлздэг байна. Гэхдээ олонх компани архины согтолтоос гадна марихуан гэх мэт хар тамхинд хордсон хүмүүст нэг удаагийн хордлого тайлах эмчилгээ хийдэг аж.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “ФМ 104,5 байраас гэр хорооллын дундуурх авто зам, 0.8 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”-ын ажил
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/016

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос **“ФМ 104,5 байраас гэр хорооллын дундуурх авто зам, 0.8 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”-ын** ажлыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул **www.tender.gov.mn**, хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45 хоногийн** туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо: (2016, 2017, 2018 он) борлуулалтын дундаж орлого нь төсөвт өртөгийн 30 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2016, 2017, 2018 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2016, 2017, 2018 оны аль нэг жилд төсөвт өртгийн 40 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм
Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

Зам, тээврийн яамнас олгодог:

2.8.1.3 Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах

Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнас олгодог:

ЗТ сайдын 2013 оны 152 дугаар тушаалаар батлагдсан журмын

1.6 ЗБ-1-6 /Зкм хүртэл/ үүнээс дээш эсвэл,

ЗТБХБ сайдын 2010 оны 47 дугаар тушаалаар батлагдсан журмын

2.8.1 Хатуу хучилттай зам барих эсвэл,

ЗТ сайдын 2018 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан журмын

2.8.2.1 Хатуу хучилттай зам барих

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. **10,000,000 /арван сая/ төгрөг**

Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 07 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хүчинтэй байна.

Тендерийг **2019 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 14 цаг 50 минутаас өмнө** системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн 15 цаг 00 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер **ирүүлэх эрхгүй.**
Дотоодын давуу **эрх тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг **www.tender.gov.mn, www.ub-procurement.mn** цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810

Эдийн засаг

БАНК САНХҮҮ

Татан буулгасан “Капитал” банк нь системийн ач холбогдолгүй

Г.Илч
ЗГМ

Энэ он болон ирэх жилүүдэд Монгол Улсын макро эдийн засгийн төлөв болон цаг үеийн сэдвээр ОУВС-гийн Монгол Улс дахь суурин төлөвлөгч Нэйл Сакертай ярилцлаа.

-Монгол Улсад хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн явц хэрхэн үргэлжилж байна вэ?

-“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” гурван жилийн хугацаатай батлагдсан. Одоо бид хэрэгжилтийнхээ сүүлийн хагаст орж байна. Хөтөлбөр хэрэгжсэн эхний хагаст үр дүн маш сайн байлаа. 2016 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орж, төсвийн алдагдал ДНБ-ий 17 хувьтай тэнцсэн зэрэг таагүй үзүүлэлт цөөнгүй байсан. Гадаад валютын нөөц шавхагдаж байсан тэр үетэй харьцуулбал өдгөө нөхцөл байдал эрс сайжирсан. Эдийн засгийн өсөлт долоон хувь руу дөхлөө. Гадаад валютын нөөц гурван тэрбум ам.доллар давсан. Засгийн газрын өрийн түвшин өндөр хэвээр байгаа ч буурах хандлагатай.

Энэ бүхэн Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зөв бодлогын үр дүн. Монголбанк ч бодлогын зөв арга хэмжээ хэрэгжүүлсэн. Одоо санхүүгийн салбарыг бэхжүүлэх нь чухал байна. Монголбанкны зүгээс арилжааны банкуудыг өөрийн хөрөнгөө хангалттай түвшинд хүргэхэд илүү их анхаарч ажиллаж байна.

-Арилжааны банкуудад активын чанарын үнэлгээ хийсэн. Үүний үр дүнд Монголбанкнаас “Капитал” банктай холбоотой шийдвэр гаргалаа гэж ойлгож байна. Төв банкны авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг ОУВС эрхэн дүгнэж байна вэ?

-Санхүү бол эдийн засгийг дэмжиж байх ёстой чухал салбарын нэг. Энэ салбарыг бэхжүүлэх нь ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн гол цөм байсан. Арилжааны банкууд зөв зохистой хяналт шалгалттай, хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй, эдийн засгийг дэмжих шаардлагатай зээлийн эх үүсвэрийг зах зээлд нийлүүлэх чадвартай, жижиг, дунд, шинээр үүсэж байгаа болон эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмждэг байх ёстой.

Активын чанарын үнэлгээ бол санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх цогц хөтөлбөрийн эхний алхам байсан. Хүн ямар нэг өвчин туслаа гэхэд нөхцөл байдал ямар байна вэ гэж эмчийн үзлэг шинжилгээ хийлгэдэг шиг банкуудад үнэлгээ



Одоо хэрэгжүүлж буй бодлогынхоо зөв голд-рилоос халихгүй байж чадвал урт хугацаандаа Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал маш өөдрөг байгаа.

С.Батсайхан / ЗГМӨ

“Капитал” банкны дампуурал санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхгүй

хийсэн. Үүн дээр үндэслэн дараагийн алхмууд хийсэн.

Активын чанарын үнэлгээгээр ихэнх банк хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй болох шаардлагатай нь тодорхой болсон. Ганц, хоёр банк өөрийн хөрөнгийн дутагдалтай байгаа нь харагдсан. Энэ үр дүнд үндэслэн системийн ач холбогдолгүй, жижиг банкуудыг хэрэв тогтоосон хугацаанд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж чадахгүй бол татан буулгана гэдэг шийдвэрийг Монголбанк хуулийнхаа дагуу мэдэгдсэн.

Системийн ач холбогдолтой банкуудад төрөөс өөр байдлаар оролцох шаардлагатай болсон. Харин энэ долоо хоногт нэг банкийг татан буулгах шийдвэр гарсан. Арилжааны банкууд Монголбанкнаас тогтоосон зохистой байдлын үзүүлэлтүүдийг хангаж ажиллах ёстой байдаг. Харин “Капитал” банк удаан хугацаанд зохистой харьцаануудыг хангалгүй ажилласнаас гадна заасан хугацаанд шаардлагыг биелүүлж чадаагүй учраас ийм шийдвэрт хүрсэн.

-Энэ шийдвэр банкны системд сөргөөр нөлөөлөх үү?

-Энэ шийдвэр гарснаар Монголын банк санхүүгийн салбарын тогтвортой байдалд сөрөг үр дагавар гарахгүй. Яагаад гэвэл, татан буулгасан банк нь системийн ач холбогдолгүй, жижиг банк. Монголбанкны гаргасан шийдвэрийг бид зөв зохистой

● **Банкны салбарт хүлээгдэж буй дахин хөрөнгөжүүлэх үйл явцыг хэрэгжүүлснээр хөтөлбөрийн дараагийн үнэлгээ хийх боломж бүрдэнэ. Үнэлгээ хийснээр хандивлагч орнуудаас орж ирэх санхүүгийн дэмжлэг үргэлжлэх учиртай.**

● **Ирэх жил УИХ-ын сонгууль болно. Тиймээс энэ оны арваннэгдүгээр сард өргөн барих төсөв чухал баримт бичиг байх юм.**

● **Засгийн газар, шийдвэр гаргагчид бодлогын тогтвортой байдлаа хадгалах хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсээр ирсэн учраас ямар нэгэн ухарсан алхам гаргахгүй болов уу гэж найдаж байна.**

шийдвэр гэж үзэж байна. Ингэснээр хуулиар тогтоосон бүх журам зааврыг чанд мөрдөж ажиллах ёстой гэдэг мессежийг бусад арилжааны банкинд өгч чадсан гэж бодож байна. Энэ бол зайлшгүй хийх ёстой алхам байсан.

-Монголбанк энэ тухай

мэдээллийг олон нийтэд хэр оновчтой хүргэж чадсан бэ?

-Үйл явц хууль журмын дагуу, энгийн үргэлжилж байна. Зах зээлд ямар нэгэн замбараагүй байдал үүсээгүй. 20 сая хүртэлх төгрөгийн хадгаламж даатгагдсан учраас төлбөр төлөгч банкаар дамжуулаад хохирлыг нь барагдуулж байна. Үүнд тодорхой хугацаа шаардлагатай ч аль болох ойрын үед энэ ажлыг гүйцэтгэхийг зорьж байгаа.

Энэ зорилгоор байгуулсан сангийн үйл ажиллагааг хариуцсан Хадгаламжийн даатгалын корпораци гэж байгууллага бий. Энэ байгууллага хийх ёстой зүйлээ зохих журмын дагуу гүйцэтгэж байна. Хадгаламжаа татах зэрэг сөрөг үр дагавар бусад банкинд ажиглагдахгүй байна.

-2019 онд болоод цаашид Монгол Улсын эдийн засгийг хэрхэн төсөөлж байна вэ?

-2019 оны эдийн засгийн төлөв байдал эерэг, 6.3 хувиар өсөх төлөвтэй байна. Хэрэв зэсийн экспорт илүү сайжирвал үүнээс давж өсөх магадлалтай. Засгийн газар ажлаа маш сайн хийж байгаа.Хоёр жилийн өмнө ДНБ-ий 17 хувьтай тэнцэх хэмжээний төсвийн алдагдалтай байсан бол өнгөрсөн онд бага хэмжээний ашигтай гарсан. Энэ бол ОУВС-гийн гишүүн орнуудын түүхэнд гарч байсан маш том ахиц. Энэ онд ч маш сайн төсөв батлагдсан. Монголбанк эдийн засагт

ажиглагдаж эхэлсэн хэт халалтыг хяналтдаа оруулах чиглэлээр зөв алхам хийж эхэлсэн. Зээлийн өсөлт, импортын хэрэглээ өндөр байсныг хязгаарлахын тулд макро зохистой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа нь хэт халалтаас сэргийлэх арга хэмжээ.

Банкны салбарт хүлээгдэж буй дахин хөрөнгөжүүлэх үйл явцыг хэрэгжүүлснээр хөтөлбөрийн дараагийн үнэлгээ хийх боломж бүрдэнэ. Үнэлгээ хийснээр хандивлагч орнуудаас орж ирэх санхүүгийн дэмжлэг үргэлжлэх учиртай.

Ирэх жил УИХ-ын сонгууль болно. Тиймээс энэ оны арван-нэгдүгээр сард өргөн барих төсөв чухал баримт бичиг байх юм. Засгийн газар, шийдвэр гаргагчид бодлогын тогтвортой байдлаа хадгалах хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсээр ирсэн учраас ямар нэгэн ухарсан алхам гаргахгүй болов уу гэж найдаж байна.

“Оюутолгой”-н далд уурхайн бүтээн байгуулалт дуусаж, 2021-2022 онд үйлдвэрлэлээ эхлүүлбэл Монгол Улсын төсөвт маш их хэмжээний орлого хуримтлагдаж эхэлнэ. Тиймээс тэр орлогыг сайн хуримтлуулж, зөв зохистой зарцуулахад анхаарах үнэтэй гэж бодож байна. Одоо хэрэгжүүлж буй бодлогынхоо зөв голдрилоос халихгүй байж чадвал урт хугацаандаа Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал өөдрөг байгаа. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

64.4

Сая төгрөг. Монголын хөрөнгийн биржийн баасан гарагийн арилжаагаар 20 хувьцаат компанийн 64.4 сая төгрөгийн 323 мянган ширхэг хувьцааг арилжлаа.

» ХУВЬЦАА

7.3

Хувь. “Ард Даатгал” компанийн хувьцааны ханш 7.3 хувиар чангарч, ханшийн өсөлтөөрөө хөрөнгийн биржийн арилжааг тэргүүлээ. Харин “Монгол Шуудан” компанийн үнэт цаасны ханш 3.5 хувиар уруудсан нь огцом уналтад тооцогдож байна.

» ҮНЭТ ЦААС

981

Сая төгрөг. Засгийн газрын үнэт цаас хоёрдогч зах зээлийн багцын арилжаагаар 9,564 ширхэг үнэт цаасыг 981 сая төгрөгөөр арилжлаа.

» ТҮҮХИЙ ЭД

2.8

Сая тонн. Southgobi Resources компанийн нүүрсний борлуулалт 2018 онд 1.6 дахин буурч, 2.8 сая тоннд хүрчээ. Энэ нь Сэхэ боомтод гарсан сааталтай холбоотой гэж тус компани мэдээллээ.

» БОРЛУУЛАЛТ

12.5

Тэрбум ам.доллар. LVMH компанийн борлуулалтын орлого энэ оны эхний улиралд 16 хувиар өсөж, 12.5 тэрбум евро буюу 14.1 тэрбум ам.долларт тэнцлээ. Тус компани Christian Dior-ийн эхний үсгүүдээр нэрлэсэн спорт гутал, Louis Vuitton брэндийн 1200 ам.долларын үнэтэй бүстэй цүнх танилцуулсан. Тус компанийн загварын хувцасны болон арьсан эдлэлийн салбар нэгжийнх нь орлого 15 хувиар өссөн байна.

» САНХҮҮ

0.1

Хувь. Ам.доллартай харьцах иенийн ханш 111.19 нэгжид хүрлээ. Харин фунттай харьцах ам.долларын ханш 0.1 хувиар суларч, 1.3067 нэгжтэй тэнцэв.

» ТҮҮХИЙ ЭД

63

Ам.доллар. Олон улсын зах зээлд West Texas төрлийн түүхий газрын тосны ханш 0.5 хувиар чангарч, баррель нь 64 ам.долларт хүрлээ.

» ТАВААР

0.2

Хувь. Лондоны металлын биржид хөнгөн цагааны ханш 0.2 хувиар чангарч, 1863 ам.доллартай тэнцсэн бол цайрын үнэ 2.2 хувиар өсөж, 2926 ам.долларт хүрэв.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,631.77
Евро	2,970.87
Японы иен	23.53
ОХУ-ын рубль	40.79
БНХАУ-ын юань	391.71
БНСУ-ын вон	2.31

төсөв

Төсвийн хөрөнгө оруулалтын 31 хувь нь зам тээвэрт зориулагджээ

Төсвийн хөрөнгө оруулалтын зардал энэ оны эхний улиралд 59.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Зардлын 31 хувь нь зам, тээврийг чиглэжээ. Улмаар барилга, хот байгуулалт болон боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалт жин

дарсан байна. Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнээс 2.4 дахин бага байна. Засгийн газар 2019 онд төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, бодит салбаруудын өсөлтийг дэмжих зорилт тавиад байгаа юм. Энэ онд 1.6 их наяд

төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөжээ. Энэ нь өмнөх оны гүйцэтгэлээс хоёр дахин өссөн дүн юм. Ингэхдээ сургууль, эмнэлэг, гаалийн шинэчлэлд зарцуулахаар төлөвлөсөн байна. Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар 2012-2017 онд


төсвийн хөрөнгө оруулалтын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ дунджаар 9.3 хувьтай байгаа. Энэ нь бүс нутгийн орнуудын дундаж 6.3 хувиас өндөр үзүүлэлт юм. Тиймээс төсвийн хөрөнгө оруулалт хэт өсөх, үр ашиггүй

байх нь төсвийн хүндрэлийн гол шалтгаан болж байсан гэж дүгнэжээ. Энэ оны төсөв тэлж буй нь эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэж төв банк үзэж байна. Гэхдээ эрэлтийн шалтгаантай инфляцийг нэмэгдүүлэх нөлөөтэй байгаа юм. [ЗГМ]

ЗГМ: ИНФОГРАФИК

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн бүтэц

2019 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн 35 хувийг БНХАУ дангаараа бүрдүүлэхээр байна. Тус улсын ДНБ-ий тэлэлтийн хурд 1990 оноос хойших доод цэгтээ хүрч саарсан ч дэлхийн эдийн засгийн өсөлтийн гуравны нэгийг бүрдүүлсээр байх нь. 14 их наяд ам.доллараар хэмжигдэж буй Хятадын аварга эдийн засаг жилд зургаан хувийн хурдтай өсөж буй нь дэлхийн түүхэнд ажиглагдаагүй үзүүлэлт аж. [ЗГМ]



БИЗНЕС ЭРХЛЭЛТ

“Техник импорт” орлогоо өсгөнө

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Техник импорт” компани энэ онд борлуулалтын орлогоо 30 хувиар нэмэгдүүлж, 120 орчим тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж байна.

Энэ онд барилгын салбарт сэргэлт ажиглагдаж буй нь борлуулалтаа нэмэгдүүлэх боломж олгоно гэж тус компанийн удирдлага үзэж байгаа аж. Тус компани 2018 он 93.9 тэрбум төгрөгийн орлого олсон нь 2017 оныхоос 35.7 тэрбум төгрөг аж. Компанийн борлуулалтын 50 орчим хувийг цемент болон бусад

барилгын материал бүрдүүлдэг.

Мөн 20 орчим хувийг мотоциклийн борлуулалт эзэлдэг аж. Харин “Техник импорт” компанийн ашигт ажиллагаа нь 2.7 тэрбум төгрөгт хүрчээ. Тус компани нэгж хувьцаандаа 500 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар болсон. Энэ нь цэвэр ашгийн 27 хувьтай тэнцэж байгаа аж. Тус компани ногдол ашгаа энэ сарын 11-нээс компанийн байрандаа олгож эхэлжээ. Харин хувьцааны ханш нь сүүлийн нэг жилийн доод түвшинд буюу 13800 төгрөгтэй тэнцэж байна. [ЗГМ]

Эдийн засаг

Тонн нүүрсээ
70 бүс 90
ам.доллараар
борлуулах боломж
ЭТТ-д байна

Б.Баяртогтох

@bayartogtokhZGM

Монгол Улс 2019 онд түүхэндээ анх удаа 42 сая тонн нүүрс экспортолж, үүнээс хамгийн багадаа 1.3 их наяд төгрөг олохоор төлөвлөсөн. Ийм хэмжээний мөнгийг нүүрсний орлогоос бүрдүүлснээр энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар далайцтай ажлууд хийгдэхээр байгаа. Нийслэл болон орон нутагт шаардлагатай сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт нийгмийн чанартай бүтээн байгуулалтыг уул уурхайн мөнгөөр барина. Ингэснээр ирэх оны сонгуулийн өмнө иргэдээс эерэг оноо цуглуулах эрх баригчдын хүслийг нүүрсний экспорт, түүнээс хүртэх орлого гүйцэлдүүлэх учиртай. Тэгвэл 1.3 их наядыг төсөвт оруулах коксжих нүүрсний зах зээлийн 2019 оны төлөв байдлыг Бээжингээс сурвалжиллаа.

Коксжих нүүрсний үнэ энэ онд өмнөх жилүүдтэй харьцуулахад хамаагүй өндөр өсөлттэй байх нь. Төсвийн орлого зарим жил төлөвлөснөөс дутах эрсдэл гардаг байсан. Тэгвэл ийм эрсдэлийн талаар одоо ярихад эрт байна. Манай улс зөвхөн нүүрснээс 1.3 их наядаас давсан хэмжээний орлого олох боломж бүрджээ. Үүнийг ашиглаж чадвал “Эрдэнэс Тавантолгой” гэхэд 2018 оны ашгаа хоёр дахин нэмэгдүүлж, 1.5 их наяд төгрөгийн ашигтай ажиллахаар байна. Тухайлбал, тус компанийн хувьд нэг тонн нүүрсээ 20 орчим ам.доллараар өсгөж, хамгийн багадаа 90 хүртэлх ам.доллараар борлуулахад ногдол ашгийн хэмжээ нь хоёр дахин нэмэгдэнэ гэсэн үг.

Сүүлийн гурван жил дараалан нүүрсний экспортын түүхэн дээд



С.Батсайхан / ЗГМ©

Коксжих нүүрсний
зах зээлийн сэргэлт
үргэлжилнэ

үзүүлэлтээ бид шинэчилсэн бол энэ онд дахин шинэчлэхээр байна. Тэрчлэн өмнөд хөршийн импортын нүүрсний зах зээлд өөрийн орон зайгаа бэхжүүлэх, улмаар Хятадтай нүүрсний худалдаан дээр стратегийн түвшинд харилцах боломж гарч ирлээ. Тодруулбал, тэдний хэлсэн үнээр нүүрсээ зарах бус харин бид өөрсдөө худалдах үнээ санал болгох хэмжээнд буюу хэлэлцээрийн ширээнд суух нааштай “уур амьсгал” зах зээлийн орчинд бүрджээ. Эдгээр мэдээллийг нэг дор агуулсан “Дэлхийн коксжих нүүрсний нөөц ба зах зээл” сэдэвт олон улсын чуулган Бээжин хотноо энэ сарын 10-11-нд болов. Уг чуулганд оролцсон илтгэгчдийн дийлэнх нь коксжих нүүрсний үнэ өснө, дунд хугацаанд өсөлт тогтвортой байна, Хятадын гангийн хэрэглээ огцом буурахгүй гэсэн мессеж өгсөн юм.

Ес дэх удаагийн нүүрсний салбарын томоохон тоглогчдын цугларалт 2019 оны зах зээлийн төсөөллүүдийг өөдрөг хэдий ч бодитой таамаг гэж үзэж байна. Энэхүү чуулганыг “Coal Mongolia” чуулганыг зохион байгуулагч “Гложекс Консалтинг” компани Хятадын Fenwei Energy байгууллагатай хамтран гурав

дахь жилдээ зохион байгууллаа. Өнгөрсөн жилийнхээс илүү өөдрөг хүлээлттэй хурал болж байгааг чуулганы зохион байгуулагч Л.Наранбаатар хэлсэн юм.

● Австралитай хийж буй Хятадын диплоамат маргаан Монголыг өөрөөр харахад хүргэж байна.

● Коксжих нүүрсний үнэ он гарснаас хойш 20 орчим ам.доллараар өсжээ.

● Өмнөд хөршийн гангийн зах зээлд Монгол руу улам ойртож байна.

Коксжих нүүрсний 2019 оны эрэлт, хэрэгцээ, үнийн чиг хандлагыг тодорхойлохоос гадна Хятадын төрийн бодлоготой холбоотой хамгийн бодитой мэдээллийг уг форум хуваалцаж ирсэн. 500 гаруй төлөөлөгч хоёр өдөр саатсан чуулга уулзалтад анх удаа ОХУ-ын төлөөлөгч ирж, өөрсдийн нүүрсний салбар дахь бодлогоо танилцуулав. Түүний илтгэлд Монгол, Австрали хам-

гийн их дурдагдсан. Учир нь, хойд хөршийн хувьд энэ хоёр улс нүүрсний зах зээлд хамгийн хүчтэй өрсөлдөгч нь болж байна. Энэ он гарснаас хойш S&P Global Platts-ийн судалгаагаар коксжих нүүрсний үнэ тонн тутамд 20 гаруй ам.доллараар өсжээ.

Fenwei Energy компанийн дэд ерөнхийлөгч Сара Лю-гийн хэлснээр нүүрсний үнэ энэ оны турш тогтвортой байхаар байна. Түүний илтгэлд гарснаар, нэг тонн коксжих нүүрс 250 орчим ам.долларт хүрч, өмнөх оныхоос давах аж.

Монголыг харах өмнөд хөршийн нүүрсний бодлого өөрчлөгдөж, тэд биднийг Австралийн зиндаанд авч үзэж байна. Сайн мэдээ гэвэл Монголоос авах нүүрсний хэмжээгээ өмнөд хөрш 36 сая тонноор хязгаарлахгүй илүү өсгөх боломжтой гэдгээ “Дэлхийн коксжих нүүрсний нөөц ба зах зээл” чуулганы үеэр Хятадын тал онцолсон юм. Ингэж чуулганы индрээс Хятадын нүүрс ассоциацийн нөлөө бүхий эрхэм мэдэгдсэн нь ОХУ болон Австрали, Индонезийн төлөөлөгчдөд тийм ч таатай сонсогдоогүй нь лавтай. Учир нь эдгээр орнууд Монголыг өөрсдийн өрсөлдөгчөө хэмээн

үздэг. Гэтэл Монголыг товойлгон хэлсэн нь өмнөд хөрш тогтвортой нийлүүлэгч хайж байгаагаа нэг талаар зарласан хэрэг боллоо. Тэрчлэн сайн чанарын коксжих нүүрсний эрэлт өндөр байх нь. БНХАУ болон Австралийн хооронд өрнөж буй үл ойлголцол хоёр орны худалдаа, тэр тусмаа нүүрсний зах зээлд томоохон доржилт авчраад байгаа. Энэ нь нөгөө талдаа ОХУ болон Монголд нүүрсний үнээ өсгөх, Хятадтай илүү стратегийн түвшинд нүүрсээ нийлүүлэх тэрхүү боломжийг олгоод буй.

Өмнөд хөршийн хэрэгжүүлж буй “Цэнхэр тэнгэр” төлөвлөгөөний хүрээнд аж үйлдвэрийн томоохон бүсүүдээ далайн эргээс хойд бүс рүүгээ шилжүүлж эхэлсэн. Энэ нь Хятадын зах зээл Монгол руу улам ойртож буй хэрэг. Далайн эргийн коксжих нүүрсний үнэ эх газрын гүндээ буюу аж үйлдвэр шинээр хөгжиж, гангийн үйлдвэрлэл явагдаж буй өмнөд хөршийн хойд хэсэгт илүү үнэтэй болж эхэлж байна.

Сангийн яамны мэдээллээр энэ оны нэгдүгээр улиралд манай улсын нүүрсний экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15 хувиар өсөж, 7.8 сая тонн

болжээ. Тэгвэл ирэх хоёрдугаар улиралд үүнээс ч илүү өсөлтийг бид нүүрсний экспортоос хүлээж болох нь.

Хятад, Австралийн одоогийн хориг арга хэмжээнд хоёр тал буулт хийлгүй багагүй хугацаа өнгөрүүлсэн. Энэ байдал Австралийн сонгууль хүртэл үргэлжилж мэдэхээр байгааг БНХАУ-д суугаа Австралийн Элчин сайд хэлж байсан юм. Тэрбээр “Хятадын хил гаалийн шинэчлэл хэтэрхий удааширч байгаа. Энэ нөхцөл байдалд ахиц гарахгүй бол бидний зүгээс өөр зах зээлийг судалж эхэлнэ” гэв. Энэ нь нөгөө талдаа ОХУ болон Монголд нүүрсний үнээ өсгөх, Хятадтай илүү ажил хэрэгч яриа өрнүүлэх боломжийг олгож байна.

Монголоос энэхүү чуулганд “Эрдэнэс Тавантолгой”, МАК, “Өсөх зоос”, “Энержи Ресурс”, “Мон Эн Ко” компаниас гадна “Монгол нүүрс” ассоциаци бодлогын түвшинд оролцож, шинэ яриа хэлэлцээ эхлүүлэх уулзалтыг өрнүүлсэн юм. Манай улсын төсвийн орлогыг зэстэй дөрөө харшуулан бүрдүүлж буй нүүрсний үнэ 2019 онд тогтвортой байхаас гадна ашгаа нэмэгдүүлэх завшааныг зах зээл олгож байна. [ЗГМ]



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

СОНИРХОЖ БУЙ АЖ АХУЙ НЭГЖИД
ТАВИГДАХ ШААРДЛАГА

16 ДАВХАР ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ОРОН СУУЦНЫ
3 БАРИЛГАД ХИЙГДЭХ АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

1	Сонгон шалгаруулалтын нэр	ХУД-ийн 11 хорооны нутагт баригдах 16 давхар үйлчилгээтэй орон сууцны 3 барилгын угсралтын ажлын гүйцэтгэгч сонгох
2	Гүйцэтгэх ажил	1. Барилга угсралтын ажил /хавсралтад заасан хэмжээгээр/ 2. Барилгын цахилгаан, холбоо дохиолол, галын дохиоллын иж бүрэн ажил 3. Барилгын сантехникийн иж бүрэн ажил 4. Заслалын ажил
3	Оролцогчдод тавих шаардлага	1. Сүүлийн 3 жилийн хугацаанд 10 давхараас дээш барилгын угсралтын ажил гүйцэтгэсэн туршлагатай байх 2. 16 давхар хүртэлх барилга угсралтын тусгай зөвшөөрөлтэй байх
4	Бүрдүүлэх материал	1. ААН-ын гэрчилгээ, дүрэм тусгай зөвшөөрлийн хуулбар 2. Компанийн танилцуулга /Инженер техникийн ажилтнуудын танилцуулга, ХАБЭА-ын ажилтантай байх/ 3. Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт 4. Үнийн санал. Захиалагчаас хангах материал: • Бетон зуурмаг • Арматур • Заслал чимэглэлийн үндсэн материал • Сантехникийн болон цахилгааны материал
5	Сонгон шалгаруулалтын хугацаа	2019 оны 04 сарын 08-ны өдрөөс ажлын 21 хоног

№	Ажлын нэр	х/н	Ажлын тоо хэмжээ	
			1 барилгад	Нийт 3 барилгад
1	Төмөр бетон цутгамал карказ	м2	15,956	47,869
2	Полистрол хавтан угсралт	м2	20,600	61,800
3	Шавардлага	Хана	м2	27,000
		Дам нуруу, амалгаа	м2	2,600
4	Полистрол ханын хар замаска	м2	41,200	123,600
5	Шал бетон	м2	11,900	35,700
6	Цонхны тавцан суулгах	у/м	700	2,100
7	Цагаан замаска	Хана	м2	39,400
		Тааз	м2	15,800
8	Обой	Хана	м2	34,000
9	Эмульс	Тааз	м2	15,800
		Хана	м2	1 1,400
10	Плита	Хана	м2	5,900
		Шал	м2	1,000
11	Паркетан шал	м2	10,100	30,300
11	Дотор хаалга	ш	486	1,458
13	Шатны хонгил коридорын гантиг	м2	2,200	6,600
14	Гадна фасад	м2	8,000	24,000
15	Дээвэр	м2	1,100	3,300

Жич: Зургийн өөрчлөлт болон талбай дээрх хийгдэх нэмэлт ажлын тооцоо ороогүй

ЖИЧ: САНТЕКНИК, ЦАХИЛГААН БОЛОН ХОЛБОО ДОХИОЛОЛ, ӨРӨГ, ШАВАРДЛАГА, ЗАСЛАЛЫН АЖЛЫГ ТУС ТУСАД НЬ САЛГАЖ АВАХ БОЛОМЖТОЙ.

Материал хүлээн авах хаяг:



Улаанбаатар хот, ХУД дүүрэг, 11-р хороо, Их Монгол улсын гудамж Маршал хотхон 104 дүгээр байранд байрлах “Эко констракшн” ХХК-ийн Үйлдвэрлэлийн алба



Холбоо барих утас: 7014 9919, 7012 9919



Факс: 7012 9919